

Монгол хэлний сурах бичгийн цахим санд суурилсан
үгийн аймгийн бүртгэл судалгаа
(Ерөнхий боловсролын сургуулийн I-V анги)

Түвдэндоржийн БАТБЯМБА*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Компьютер хэл шинжлэлийн салбар

Received: 20 September 2025 / Accepted: 24 October 2025 / Published: 30 December 2025

Хураангуй: Монгол улсын боловсролын салбарт мөрдөгдөж байгаа монгол хэлний хөтөлбөрийн хүрээнд бага ангийн монгол хэлний сурах бичгүүдийг цуглуулан цахим сан бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж, түүндээ тулгуурлан хэл боловсруулалтын программуудыг гараар тэмдэглэгээ хийх аргатай хослуулан, сурах бичгийн нийт үгийг үгийн аймгаар ангилж, давтамжийг тооцоолсон судалгааны үр дүнгээ энэхүү өгүүллээр танилцуулахыг зорив. Бид энэхүү зорилтынхоо хүрээнд 1-5-р ангийн монгол хэлний сурах бичгүүдийг харьцуулан үзэж, боловсруулалт хийж, тусгай мэргэжлийн судлаачдад гарын авлага болгон ашиглах боломжтой тоо баримтад суурилсан судалгааны үр дүнг тайлбарлан өгүүллээ. Энэ нь эх хэлний боловсролыг олгодог бага ангийн монгол хэлний сурах бичгийн хэлийг тооцооллын үүднээс шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлахын ач холбогдлыг тодруулахад чиглэсэн билээ.

Түлхүүр үгс: сурах бичиг, цахим сан, өгөгдөл, үгийн аймаг, давтамж

A Study of the Quantitative Analysis of Parts of Speech
in the Educational Book of Mongolian Language
(Primary School Grades I-V)

BATBYAMBA Tuvdendorj

Department of Computational Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract. We created electronic database by collecting Mongolian language textbooks for elementary school which were published within the framework of the Mongolian language program implemented in the field of education in Mongolia. Then based on it, the total number of words, syllables and letters of the textbook was recorded using language processing programs that were combined with the manual marking method. We aimed to present the results of the research, which was classified by parts of speech and the frequency with this article. For the accomplishment of this

* © Т. Батбямба, 2025, Email: batbyamba_t@mas.ac.mn



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

objective, we compared and processed textbooks for grades 1-5, and explained the results of data-based research that can be used as a guide for specialized researchers. Our purpose is clarifying the importance of studying the language of Mongolian textbook for elementary school which provide mother tongue education with a scientific basis from the aspect of computation.

Key words: Textbooks, Electronic Corpus, Data, Parts of Speech, Frequency

1. Удиртгал

Орчин үеийн хэл шинжлэлийн хөгжилтэй уялдан сурах бичгийн хэлийг судлах ажил ихэд эрчимжиж байна. Ялангуяа үндсэн хуульдаа заасан төрийн албан ёсны хэлээр бичигдсэн сурах бичгийн хэлийг судлах ажил нь бусад хичээлийг цаашид сайн сурахын суурь болдог тул судлаачид ихээхэн анхаарал хандуулж байна. Учир нь аливаа улс орны хөгжлийн эхлэл нь эх хэл, түүгээр дамжуулан олгодог боловсрол байдаг. Иймд багш, сурагч, эцэг эхийг холбосон сургалтын хамгийн чухал хэрэглэгдэхүүн бол сурах бичиг хэмээн үзэж эрдэмтэн судлаачид сурах бичгийн чанар, сурагчдад үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх талаар өөр өөрийн санал бодол, туршлага, судалгааны үр дүнгээ хуваалцаж хэлэлцүүлсээр иржээ. Монгол Улсын хувьд Ж.Надмид¹, С.Сандагдорж², Б.Шалхаан³, И.И.Кирсанов, Н.Цэвгээ⁴, Н.Бэгз⁵, Ц.Оюун⁶, Н.Цэдэвсүрэн⁷, Л.Туяа⁸, Ц.Дэлгэрсайхан⁹, С.Цогбадрах¹⁰, Г.Бямбацэрэн¹¹ нарын багш, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн судлаачид судалгааны ажлын үр дүн, санал зөвлөмжөө танилцуулж ирсэн бөгөөд тэдгээрийг үе үеийн сурах бичиг зохиогч, арга зүйчид ашигласаар ирсэн уламжлалтай.

Орчин үеийн хэл шинжлэлийн хөгжилтэй уялдан сурах бичгийн хэлийг судлах ажил ихэд эрчимжиж байна. Ялангуяа үндсэн хуульдаа заасан төрийн албан ёсны хэлээр бичигдсэн сурах бичгийн хэлийг судлах ажил нь бусад хичээлийг цаашид сайн сурахын суурь нь болдог тул судлаачид ихээхэн анхаарлаа хандуулж байна. Бид ч мөн монгол хэлний сурах бичгийн хэлийг тооцоо хэл шинжлэлийн үүднээс судлах ажилд өөрсдийн судалгааны ажлын үр дүнгээс танилцуулахыг зорилоо.

2. Судалгааны арга зүй

Энэхүү цахим санд суурилсан судалгааны үндсэн арга нь үгсийг материалын санд бүртгэх бөгөөд хэл зүй-үгийн сангийн нарийн задлалтаар тэмдэгжүүлэн бүрдүүлбэрийн задаргаа хийх, хам бичвэрийн аргаар хам сэдвээс үгсийг ялгах, улмаар үгийн сангийн хэрэглээний чанарыг үнэлэх, үгийн бүтэц, хэрэглээн дэх давтамжийг тогтооход Японы Васеда их сургуулийн Шинжлэх ухаан, инженерчлэлийн факультетын профессор Лоренс Антоны боловсруулсан AntConc ([http5](http://www.antcon.org)) болон EXCEL программын хэрэгслүүдийг ашиглав.

¹ Ж.Надмид *Бага сургуулийн хэл бичгийн сурах бичгийн тухай*. –“Сурган хүмүүжүүлэгч” сэтгүүл, №6. УБ., 1963. х.82-83

² С.Сандагдорж *Бага сургуулийн зарим сурах бичгийн тухай*. –“Сурган хүмүүжүүлэгч” сэтгүүл, №4, УБ., 1967. х.98-106

³ Б.Шалхаан *Сурах бичгийг боловсронгуй болгох асуудалд саналаа нэмэрлэх нь*. –“Сурган хүмүүжүүлэгч” сэтгүүл, №1, УБ., 1968. х.90-91

⁴ И.И.Кирсанов нар *Сурах бичигт тавигдах шаардлага*. –“Сурган хүмүүжүүлэгч” сэтгүүл, №3. УБ., 1970. х.73-80

⁵ Н.Бэгз *Сурах бичгийн чанар*, Үнэн сонин, 1978.8.28-ны өдрийн № 240 (13906)

⁶ Ц.Оюун *Бага ангийн эх хэлний сургалтын түүхэн туршлага, түүний агуулга, арга зүйг боловсронгуй болгох нь*, Сурган хүмүүжүүлэх ухааны дэд докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, УБ., 1997. х.144

⁷ Н.Цэдэвсүрэн *Сурах бичгийн онол арга зүйн зарим асуудалд*, УБ., 2001, х.110

⁸ Л.Туяа *Гадаад хэлний сурах бичгийн шинжлэгээний арга зүйн зарим асуудал*, УБ., 2005. х.98

⁹ Ц.Дэлгэрсайхан *Нийгмийн ухааны сурах бичгийн агуулга, арга зүйн уламжлал, шинэчлэлийн судалгаа (Монгол улсын бага боловсролын сурах бичгийн жишээн дээр)*, Доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл, УБ., 2014, х.153

¹⁰ С.Цогбадрах *Сурах бичгийн агуулга, арга зүйд тавих шаардлагыг боловсронгуй болгох нь* (Биологийн сурах бичгийн жишээн дээр), Боловсрол судлалын доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, УБ., 2018, х.167

¹¹ Г.Бямбацэрэн *Эх хэлний цагаан толгойд суралцахуйн онол, арга зүй*, УБ., 2020, х.326

Бид Монгол Улсын ЕБС-ийн I-V ангийн монгол хэлний сурах бичгийн үгийн сангаар бүрдүүлсэн:

- Ш.Оюунцэцэг, Ө.Хадаа, Д.Цогзолмаа, Т.Энхтуяа, *Монгол хэл I*, Улаанбаатар, 2020 (долоо дахь хэвлэл), 172 хуудас.
- Г.Бямбацэрэн, Г.Болормаа, Б.Лхамноржмоо, В.Хажидмаа, *Монгол хэл II*, Улаанбаатар, 2020 (долоо дахь хэвлэл), 152 хуудас.
- Ө.Цэндсүрэн, Р.Бигэрмаа, П.Жаргалсайхан, У.Нямхүү, *Монгол хэл III*, Улаанбаатар, 2020 (долоо дахь хэвлэл), 152 хуудас.
- П.Одсүрэн, Б.Гэрэлсайхан, Н.Даваасүрэн, Ц.Дашдолгор, *Монгол хэл IV*, Улаанбаатар, 2020 (долоо дахь хэвлэл), 152 хуудас.
- Л.Олзвой, Б.Оюунцэцэг, М.Энхжаргал, Ш.Отгонцэцэг, *Монгол хэл V*, Улаанбаатар, 2020 (долоо дахь хэвлэл), 152 хуудас.

гэсэн сурах бичгүүдийн анхдагч материалын санг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож үр дүнг нь харьцуулан үзэж хам цаг (synchrony)-ийн судалгаа хийсэн юм.

3. Судалгааны асуудал

Өмнөх судалгаандаа бид эх хэлний боловсруулалтад өргөн хэрэглэдэг “Онцлогийг тодорхойлох арга” (Attribute Description Method)-аар материалын сандаа тэмдэг хадаж, Монгол хэлний тухай хуулийн дагуу Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны дэргэд байгуулсан ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, МУИС, МУБИС-ийн эрдэмтдийн ажлын хэсгээс боловсруулсан “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” (2018)-д *“Ерөнхий боловсролын сургуулийн сургалтад мөрдөж байгаа жинхэнэ нэр, үйл үг, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний үг, орны нэр, цагийн нэр, холбох үг, баймж үг, бүтээвэр үг, дүрс дуурайх үг, авиа дуурайх үг, аялга өгүүлбэр, дутмаг үйл үг”* (МХЗБДЖТ., 2018) гэж тэмдэглэсэн бол “Суурь боловсролын сургалтын хөтөлбөр” (сайжруулсан хоёр дахь хувилбар, 2019)-ийн 6.1-д *“Уншсан эхэд орон цагийн нэрийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох”* (БСПУЯ., 2019: 16-23) хэмээн орны нэр, цагийн нэр гэж ялгалгүй, нэг ухагдахуунаар авч үзжээ. Эндээс нэр томьёоны зөрүүтэй байдал харагдаж байна.

2022 онд МУИС, МУБИС, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн 40 гаруй эрдэмтэн судлаач хамтран хэл шинжлэлийн нийтлэг онол, орчин үеийн арга зүйн үүднээс эх хэлнийхээ бүтэц, тогтолцоог дүгнэсэн цогц судалгаа болох “Монгол хэл судлал” 15 боть бүтээлийг туурвиж олны хүртээл болгосон билээ. Уг цогц бүтээлийг монгол судлалын ерөнхий хүрээнд “Орчин цагийн монгол хэлний үгсийг юуны өмнө утга, хэлбэр, үүргээр нь гол үг, туслах үг гэж хоёр ангилна. Үгийн сангийн бие даасан утгатай, бүтэх аргатай, хэл зүйн ямар нэг айтай буюу үг зүйн хувиллаар хувилдаг, өгүүлбэрт бие дааж гишүүн болдог үгсийг гол үг гэнэ. Гол үгэнд нэр үг болон үйл үгийг өөртөө багтаасан бодит үг, нэрийг болон үйлийг төлөөлөх төлөөний үгийг оруулна. Туслах үгийг үүргээр нь холбох үг, баймж үг гэж хоёр ангилах бөгөөд холбох үгийг өгүүлбэр зүйн холбох харьцаагаар нь зэрэгцүүлэн холбох, захируулан холбох гэж ангилна. Баймж үгийг утга, үүрэг, байрлалаар нь утгах, дагах баймж гэж ангилна. Завсрын буюу хоёрдмол шинжтэй нэгж нь шүтэн барилдагч талуудын аль алиных нь шинжийг хадгалахын зэрэгцээгээр харьцангуй бие даасан шинжтэй бөгөөд үгийн сангийн бие даасан утгагүй боловч заримдаг утгатай байна. Энэхүү завсрын үг буюу дуурайх үгийг язгуур утгаар нь дүрс дуурайх, авиа дуурайх гэж ангилна” (Өнөрбаян, 2022:64) гэсэн судалгааг хүлээн зөвшөөрч даган мөрдөж байна. Иймээс бид “Class I_V” өгөгдлийн сан дахь нийт үгийг аймаглахдаа тухайн үгийн өгүүлбэрт гүйцэтгэж байгаа үүрэг, байрлалыг харгалзан үздэг өгүүлбэр зүйн зарчимд тулгуурлан эрдэмтэн Ц.Өнөрбаяны “орчин цагийн монгол хэлний үгийн аймгийн тогтолцоог хэл зүй, утга зүй, үгийн сангийн бүхий л талаас судлан, бүтэц хэл шинжлэлийн аргыг ашиглан, хоёртын системээр тогтоосон” (Өнөрбаян, 2022: 64) дээрх ангиллыг баримталаа.

Сурах бичгийн цахим сангийн давтамжийн тооцооллоос үзвэл “Class_I” санд 6636 үг, “Class_II” санд 20312 үг, “Class_III” санд 27458 үг, “Class_IV” санд 37446 үг, “Class_V” санд

32156 үг, нийт 124008 үг сурах бичгийн үгийн санд бүртгэгджээ. Тэдгээрээс “Class_I” цахим сангийн хэл зүйн хувилалтай 2665, “Class_II” цахим сангийн хэл зүйн хувилалтай 5379, “Class_III” цахим сангийн хэл зүйн хувилалтай 6430, “Class_IV” цахим сангийн хэл зүйн хувилалтай 8406, “Class_V” цахим сангийн хэл зүйн хувилалтай 7526, нийт 30426 үгийн хүрээнд үгийн аймгийн тооцооллыг хийв. Тооцооллыг цахим сан тус бүрээр гаргаснаа үзүүлбэл дараах байдалтай байна. Үүнд:

3.1. “Монгол хэл – I”




График 1. “Class_I” цахим сангийн үгийн аймгийн тооцоолол

“Монгол хэл–I” сурах бичигт үгийн аймгийн давтамжаар хамгийн их нь жинхэнэ нэр бөгөөд нийт цахим сангийн 45.63%-ийг эзэлж байгаа бол түүний дараа үйл үг 32.75%-ийг, тэмдэг нэр 10.51%-ийг, төлөөний үг 3.26%-ийг, орон цагийн нэр 2.33%-ийг, тооны нэр 1.50%-ийг, дагах баймж үг 0.94%-ийг, угтах баймж үг 0.67%-ийг, захируулан холбох үг 0.45%-ийг, зэрэгцүүлэн холбох үг 0.64%-ийг, авиа дуурах үг 0.68%-ийг дүрс дуурайх үг 0.64%-ийг тус тус эзэлж байна.

Орчин цагийн монгол хэлний үгсийг утга, хэлбэр, үүргээр нь ангилсан ангиллын дагуу авч үзвэл (Өнөрбаян, 2022:67) дараах тооцоолол гарчээ. Үүнд,

- Жинхэнэ нэр, үйл үг, тэмдэг нэр, төлөөний нэр, орон цагийн нэр, тооны нэр гэсэн *гол үгс* нь цахим сангийн 95.98%-ийг эзэлж байна.
- Зэрэгцүүлэн ба угсруулан холбох үг, угтах ба дагах баймж гэсэн *туслах үгс* нь цахим сангийн 2.7%-ийг эзэлж байна.
- Авиа ба дүрс дуурайх гэсэн завсрын үгс нь цахим сангийн 1.32%-ийг тус тус эзэлж байна.

3.2. “Монгол хэл – II”




График 2. “Class_II” цахим сангийн үгийн аймгийн тооцоолол

Графикаас үзэхэд, “Монгол хэл-II” сурах бичгийн цахим сангийн 42.92%-ийг жинхэнэ нэр, 40.82%-ийг үйл үг, 9.20%-ийг тэмдэг нэр, 3.16%-ийг төлөөний үг, 1.37%-ийг орон цагийн нэр, 0.84%-ийг тооны нэр, 0.44%-ийг дагах баймж, 0.39%-ийг утгах баймж, 0.33%-ийг захируулан холбох үг, 0.20%-ийг зэрэгцүүлэн холбох үг, 0.22%-ийг авиа дуурайх үг, 0.11%-ийг дүрс дуурайх үг тус тус эзэлж байна.

Түүнчлэн цахим сангийн үгсийг утга, хэлбэр, үүргээр нь ангилсан ангиллын дагуу авч үзвэл, гол үгс 98.31%-ийг, туслах үгс 1.36%-ийг, завсрын үгс 0.33%-ийг тус тус эзэлжээ.

3.3. “Монгол хэл – III”




График 3. “Class_III” цахим сангийн үгийн аймгийн тооцоолол

Графикаас үзэхэд “Class_III” сурах бичгийн цахим сангийн 6430 хэл зүйн хувилалтай үгийн 40.50%-ийг жинхэнэ нэр, 44.34%-ийг үйл үг, 5.46%-ийг тэмдэг нэр, 3.31%-ийг төлөөний үг, 2.67%-ийг орон цагийн нэр, 1.59%-ийг тооны нэр, 0.31%-ийг дагах баймж, 0.34%-ийг утгах баймж, 0.51%-ийг захируулан холбох үг, 0.64%-ийг зэрэгцүүлэн холбох үг, 0.22%-ийг авиа дуурайх үг, 0.11%-ийг дүрс дуурайх үг тус тус эзэлж байна.

“Class_III” сурах бичгийн цахим сангийн хувьд 97.87%-ийг гол үгс, 1.8%-ийг туслах үгс, 0.33%-ийг завсрын үгс бүрдүүлж байна.

3.4. “Монгол хэл – IV”




График 4. “Class_IV” цахим сангийн үгийн аймгийн тооцоолол

Графикаас үзэхэд “Class_IV” сурах бичгийн цахим сангийн 8406 үгийн 41.45%-ийг жинхэнэ нэр, 45.15%-ийг үйл үг, 6.80%-ийг тэмдэг нэр, 1.50%-ийг төлөөний үг, 2.70%-ийг орон цагийн нэр, 0.41%-ийг тооны нэр, 0.12%-ийг дагах баймж, 0.32%-ийг угтах баймж, 0.61%-ийг захируулан холбох үг, 0.49%-ийг зэрэгцүүлэн холбох үг, 0.28%-ийг авиа дуурайх үг, 0.17%-ийг дүрс дуурайх үг тус тус эзэлж байна.

“Class_IV” сурах бичгийн цахим сангийн хувьд жинхэнэ нэр, орон цагийн нэр, тэмдэг нэр, тооны нэр, үйл үг гэсэн гол үгс нь цахим сангийн 98.01%-ийг, зэрэгцүүлэн ба угсруулан холбох үг, угтах ба дагах баймж гэсэн туслах үгс цахим сангийн 1.54%-ийг, авиа ба дүрс дуурайх гэсэн завсрын үгс цахим сангийн 0.45%-ийг тус тус бүрдүүлж байна.

3.5. “Монгол хэл – V”




График 5. “Class_V” цахим сангийн үгийн аймгийн тооцоолол

Графикаас үзэхэд “Class_V” сурах бичгийн цахим сангийн 7526 үгийн 38.82%-ийг жинхэнэ нэр, 42.16%-ийг үйл үг, 10.56%-ийг тэмдэг нэр, 3.07%-ийг төлөөний үг, 2.36%-ийг орон цагийн нэр, 1.14%-ийг тооны нэр, 0.42%-ийг дагах баймж, 0.25%-ийг угтах баймж, 0.29%-ийг захируулан холбох үг, 0.56%-ийг зэрэгцүүлэн холбох үг, 0.26%-ийг авиа дуурайх үг, 0.11%-ийг дүрс дуурайх үг тус тус эзэлж байна. Цахим сангийн 98.11%-ийг гол үгс, 1.52%-ийг туслах үгс, 0.37%-ийг завсрын үгс эзэлжээ.

4. Судалгааны үр дүн

“Class_I-V” бүрэн цахим сангийн үгийн аймгийн тооцооллыг нэгтгэн хүснэгтээр үзүүлье. Үүнд:

Хүснэгт 1. “Class_I-V” бүрэн цахим сан дахь үгийн аймгийн тооцоолол

№	Үгийн аймаг	Class_I	Class_II	Class_III	Class_IV	Class_V	Нийт	Хувь	Жишээ нь
1	Жинхэнэ нэр	1216	2309	2604	3484	2922	2551	11,25%	гөлөг, ус, гол, ботго
2	Үйл үг	873	2196	2851	3795	3173	2887	12,35%	тарь, усал, хат, түрүүл
3	Тэмдэг нэр	280	495	351	572	795	2490	8,19%	найрсаг, сайхан,
4	Төлөөний үг	87	170	213	126	231	827	2,73%	тэр, чи, та, энэ, ийм
5	Орон цагийн нэр	62	74	172	227	178	713	2,35%	эрт, орой, доор,
6	Тооны нэр	40	45	102	35	86	308	1,02%	нэгдүгээр, сая, хоёр
7	Дагах баймж үг	25	23	20	10	32	105	0,34%	шүү, ёстой, биз, бэ
8	Угтах баймж үг	18	21	22	27	19	107	0,35%	маш, нэн, тун, бүү, яг
9	Захируулан холбох үг	12	17	33	51	22	135	0,44%	тул, төлөө, учир, бүр
10	Зэрэгцүүлэн холбох үг	17	11	41	41	43	153	0,50%	ба, бөгөөд, ийм, хэрэв
11	Авиа дуурайх үг	18	12	14	24	20	88	0,29%	мярс мярс, жийв, жийв
12	Дүрс дуурайх үг	17	6	7	14	8	57	0,19%	шовс шовс
Нийт		2665	5379	6430	8406	7526	30426		
Хувь		8.79%	17.69%	21.15%	27.64%	24.75%		100%	

Дээрх тооцооллоос үзвэл “Class_I-V” бүрэн цахим санд үйл үгийн давтамж хамгийн их буюу 42.35%-ийг, харин хамгийн бага буюу 0.19%-ийг дүрс дуурайх үг бүрдүүлжээ. Хүснэгтэд үзүүлсэн үр дүнг орчин цагийн монгол хэлний үгсийг утга, хэлбэр, үүргээр нь ангилсан ангиллын дагуу авч үзвэл, жинхэнэ нэр, үйл үг, орон цагийн нэр, тэмдэг нэр, тооны нэр бүхий гол үгс цахим сангийн 97.89%-ийг, зэрэгцүүлэн ба угсруулан холбох үг, угтах ба дагах баймж гэсэн туслах үгс цахим сангийн 1.63%-ийг, авиа ба дүрс дуурайх гэсэн завсрын үгс цахим сангийн 0.48%-ийг тус тус бүрдүүлжээ.

Уг бүрэн цахим санд гол үгс 97.89%-ийг эзэлсэн нь монгол хэлний сурах бичгээр дамжуулан сурагчдад олгох хэл зүй, үгийн сангийн суралцахуйн зорилтын:

1.4.б.-д заасан “Эх, өгүүлбэр дэх үгсийг хэн? юу? яав? гэсэн асуултаар ялгах”,

2.4а.-д заасан “Эх өгүүлбэрээс хэн? юу? ямар? хэчнээн? яах? яав? яасан? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, эх өгүүлбэр зохиохдоо зөв хэрэглэх” (БСШУЯ, 2019: 19) гэсэн заалтуудтай тохирч байна.

Туслах үгс нийт цахим сангийн 1.63%-ийг эзэлсэн нь сурах бичгээр дамжуулан суралцагчдад олгох хэл зүй, үгийн сангийн суралцахуйн зорилт 4.4а-д заасан “Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох” (БСШУЯ, 2019: 21) гэсэн гэсэн заалттай тохирч байна.

Авиа ба дүрс дуурайх гэсэн завсрын үгс цахим сангийн 0.48%-ийг бүрдүүлсэн нь бага сургуулийн сургалтын хөтөлбөрийн хэл зүй, үгийн сангийн чадварын хэсэгт “бататгасан, дэмжсэн өнгө аясын илтгэсэн үг болон ойролцоо утга, эсрэг утгатай үгийг өгүүлбэрт оновчтой хэрэглэн, өгүүлбэр эх зохиох” (БСШУЯ, 2019: 22) гэснээс өөрөөр үгийн аймгийн ойлголтын талаарх тусгайлан оруулсан заалт байхгүйтэй холбоотой хэмээн үзэж байна.

5. Дүгнэлт

1. Монгол Улсын бага боловсролын монгол хэлний сурах бичгийн хэлийг тооцоо хэл шинжлэлийн үүднээс судлахад I-V ангийн цахим санд нийт **124,008 үг** бүртгэгдсэн бөгөөд эдгээр нь монгол хэлний найруулгын бүх төрөлд идэвхтэй хэрэглэгддэг үгс байна. Тус өргөжиж буй нь ажиглагдсан бөгөөд цаашид утга зүйн талаас гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.
2. МУИС, МУБИС, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн судлаачдын хамтын бүтээл болох “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” (2018) болон “Монгол хэл судлал” (2022) 15 боть бүтээл дэх үгийн аймгийн ангилал зөрүүтэй байна. Энэ нь боловсролын сургалтын баримт бичиг, сурах бичгийн агуулгад үгийн аймгийн ойлголтыг тусгайлан авч үзсэн заалт байхгүйтэй холбоотой гэж үзэж байна. Иймээс сургалт, судалгааны байгууллагууд хамтран ажиллаж нэр томьёо, ухагдахуун, стандартын нэгдлийг хангах нь зүйтэй юм.
3. Уг судалгаанд үгийн аймгийн давтамжийн тоон үзүүлэлтүүдийг ашигласан бөгөөд энэ нь сурах бичгийн үгийн баялгийн ерөнхий төлөвийг илэрхийлж чадна. Гэхдээ үгийн давтамж өндөр гарсан нь үгийн баялаг сайн байна гэсэн үг биш бөгөөд цөөн үгийг олон давтсан тохиолдолд ийм үзүүлэлт гарч болох юм. Иймээс үгийн баялгийг илүү нарийвчлалтай тодорхойлохын тулд давхардалгүй үгийн тоо (type) болон нийт үгийн тоо (token)-ны харьцааг (TTR — *Type-Token Ratio*) тооцох нь зүйтэй. Энэхүү судалгаанд дээрх тооцоо хийгдээгүй ч үгийн давтамжийн судалгаа нь сурах бичгийн үгийн хэрэглээний чиг хандлага, бүтэц, хуваарилалтыг тодорхой хэмжээгээр илэрхийлж чадна гэж үзэж байна.
4. Хэл зохиолын хүрээлэн нь Монгол Улс дахь хэл бичиг, утга зохиолын судалгааг дагнан гүйцэтгэдэг байгууллагын хувьд МУИС, МУБИС тэргүүтэй сургалт-судалгааны байгууллагуудтай нягт хамтран ажиллаж бүх шатны боловсролын эх хэлний сургалт, судалгааны үндэс суурь, гол чиг баримжааг тогтооход оролцоогоо нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Ном зүй

А. Монгол хэлээр:

Батбаямба, Т., Алтантуяа, С., Алтангэрэл, Ч. (2021). ЕБС-ийн I ангийн монгол хэлний сурах бичгийн үгийн сан, үгийн хувиллыг цахим хэл шинжлэлийн үүднээс бүртгэн судалсан нь. *Хэрэглээний хэл шинжлэл сэтгүүл*, 2021, Боть (VI)21, Дэвтэр 1-18:89-102. [Batbyamba. T., Altantuya. S., Altangerel. Ch., An Applied Linguistic Study on Lexical and Grammatical Levels for Mongolian Language Textbook of the First Grade at the Secondary School in Mongolia. *Applied Linguistics*, 2021, 6: 89-102]

- Батбямба, Т.** (2022). Сурах бичгийн үгийн сан, хэл зүйн хувиллын тоон шинжилгээ (Монгол хэл II сурах бичгийн жишээгээр). *Хэрэглээний хэл шинжлэл сэтгүүл, Боть (VII)22, Дэвтэр 1-13*. 88-105 [Batbyamba, T. Quantitative Analysis of Vocabulary and Grammatical Inflection in a Textbook. *Applied Linguistics*, 2022, VII: 88-105.]
- Батбямба, Т.** (2023). Сурах бичгийн давтамжийн судалгаа. *МУБИС-НХУС, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны судлал, Vol.8, №.16*. 5-17. [Batbyamba, T. Studied on word frequencies of textbooks. *Journal of Humanities and Social and Sciences*, 2023, Vol.8:5-17.]
- БСШУЯ.** (2019). *Бага боловсролын сургалтын хөтөлбөр*. Улаанбаатар: Адмон принт. [*Baga bolovsrolын surgalтын hötölbör*. [Primary education curriculum] Ulaanbaatar: Admon printing. 2019: 16-23]
- БСШУЯ.** (2021). *Бага боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж /монгол хэл/*. Улаанбаатар: Адмон принт. [Bolovsrol Soyol Shinjlekh Ukhaany Yam, (2021). *Baga bolovsrolын khicheel, surgalтын үр дүнг үнелеkh shalguuryg khereglehkh zövlömж /mongol khel/*. [Ministry of Education, Culture and Science. Recommendations for the use of criteria for assessing primary education lessons and learning outcomes /Mongolian language/ Ulaanbaatar: Admon printing.]
- БҮТ.** (2019). *Боловсролын чанарын үнэлгээний судалгаа* (2015-2018 он). Улаанбаатар: Адмон принт. [Bolovsrolын Ünелgeenii Töv, *Bolovsrolын charanyн ünелgeenii судalгаа* [Educational Assessment Center. Educational quality assessment study]. Ulaanbaatar: Admon printing.]
- Бямбацэрэн, Г., Болормаа, Г., Лхамноржмоо, Б., Хажидмаа, В.** (2020). Монгол хэл II сурах бичиг (долоо дахь хэвлэл), Улаанбаатар: Мөнхийн Үсэг ХХК. [Byambatseren, G., Bolormaa, G., Lkhamnorjmoо, B., Khajidmaa, V., Mongol khel II surakh bichig (dолоо dakhi khevlel), [Mongolian language II textbook] Ulaanbaatar: Mönkhiin Üseg]
- МХЗБДЖТ.** (2018). Эрхлэн хэвлүүлсэн Нарангэрэл, Н., Зохиогчид: Болд, Л., Өнөрбаян, Ц., Базаррагчаа, М., Гантогтох, Г., Баянсан, Ж., Санжаа, Ж., Самбуудорж, О., Заяабаатар, Д., Бямбацэрэн, Г., Жумдаан, Л., Баярсайхан, М., Пүрэвжав, Э., Түвшинтөгс, Б., Элбэгзаяа, Б., Энхтуяа, Л., Даваасүрэн, Т. Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь. Улаанбаатар. [Narangerel, N., Bold, L., Önörbayan, Ts., Bazarragchaа, M., Gantogtokh, G., Bayansan, J., Sanjaa, J., Sambuudorj, O., Zayabaatar, D., Byambatseren, G., Jumdaan, L., Bayarsaikhan, M., Pürevjav, E., Tüvshintugs, B., Elbegzaya, B., Enkhtuya, L., Davaasüren, T., Mongol helnii zöv bichih дүрmiin juramlasan toli [Orthographic Dictionary of Mongolian Language]. Ulaanbaatar: Soyombo printing.]
- Одсүрэн, П., Гэрэлсайхан, Б., Даваасүрэн, Н., Дашдолгор, Ц.** (2020). Монгол хэл IV сурах бичиг (долоо дахь хэвлэл), Улаанбаатар. [Odsüren, P., Gerelsaikhan, B., Davaasüren, N., Dashdolgor, Ts., (2020). Mongol khel IV surakh bichig (dолоо dakhi khevlel), [Mongolian language IV textbook] Ulaanbaatar: Mönkhiin Üseg]
- Олзвой, Л., Оюунцэцэг, Б., Энхжаргал, М., Отгонцэцэг, Ш.** (2020) (долоо дахь хэвлэл). Монгол хэл V сурах бичиг, Улаанбаатар: Мөнхийн Үсэг ХХК. [Olzvoi, L., Oyuntsetseg, B., Enkhjargal, M., Otgontsetseg, Sh., (2020) (dолоо dakhi khevlel). [Mongolian language V textbook] Ulaanbaatar: Mönkhiin Üseg]
- Оюунцэцэг, Ш., Хадаа, Ө., Цогзолмаа, Д., Энхтуяа, Т.,** (2020), Монгол хэл I сурах бичиг (долоо дахь хэвлэл), Улаанбаатар: Мөнхийн Үсэг ХХК. [Oyuntsetseg, Sh., Khadaa, Ö., Tsogzolmaa, D., Enkhtuyaa, T., (2020), Mongol khel I surakh bichig (dолоо dakhi khevlel). [Mongolian language I textbook] Ulaanbaatar: Mönkhiin Üseg]
- Өнөрбаян, Ц.** (2022). Монгол хэл судлал, IX боть, Үг зүй. Улаанбаатар: Соёмбо принт. [MUIS-iin Mongol судlaliin hureelen., Mongol hel судlал. Ügiin san [Mongolian language studies]. Ulaanbaatar: Soyombo printing]
- Цэндсүрэн, Ө., Бигэрмаа, Р., Жаргалсайхан, П., Нямхүү, У.** Монгол хэл III сурах бичиг (долоо дахь хэвлэл), Улаанбаатар: Мөнхийн Үсэг ХХК. [Tsendsüren, Ö., Biggermaa, R., Jargalsaikhan, P., Nyamkhüü, U., Mongol khel III surakh bichig (dолоо dakhi khevlel). [Mongolian language III textbook] Ulaanbaatar: Mönkhiin Üseg]

Б. Гадаад хэлээр:

- Anthony, L.** (2002). <https://www.laurenceanthony.net/software/antconc/>. Retrieved from Laurence Anthony's AntConc: <https://www.laurenceanthony.net/software/antconc/>